



## МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ 8 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo>  
цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад  
танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2021 он | №08

**Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл:** 1,041.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,614.7 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дүнгээс 1,453.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**Төсвийн орлого:** 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 8,552.0 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 73.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол өмнөх оны мөн үеэс 2,822.6 тэрбум төгрөг буюу 49.9 хувиар нэмэгдсэн байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 100.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 73.4 тэрбум төгрөгөөр давж биелэхэд татварын орлого 2.3 хувь буюу 167.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлжээ.
- Тайлант хугацаанд орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого төлөвлөснөөс давж биелсэн бол бусад төрлийн татварын орлого 0.1-11.4 хувийн дутуу гүйцэтгэлтэй гарчээ.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 93.6 тэрбум төгрөгөөр дутуу биелж 91.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь торгуулийн орлого, газрын тосны орлогоос бусад төрлийн татварын бус орлогын төлөвлөгөө хүрч биелээгүйтэй холбоотой байна.

**Төсвийн нийт зарлага:** Нэгдсэн төсвийн нийт зарлага 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 9,563.8 тэрбум төгрөг болж 1,379.7 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 87.4 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 12.6 хувиар дутуу зарцуулагдсан ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.5 хувиар буюу 1,207.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 1.3 хувиар буюу 6.4 тэрбум төгрөгөөр өссөн бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 15.3 хувь буюу 88.4 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар 32 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн нийт зарлагын төсөв 900.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 89.4 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

**Улсын төсвийн хөрөнгө оруулалт:** Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 98.6 хувийн гүйцэтгэлтэй гарч 372.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон бол концессын эргэн төлөлтөд 189.9 тэрбум төгрөг зарцуулагдаж 92.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС


# МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ 8 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,041.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.**

## 1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 8,522.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 9,563.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,041.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,614.7 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дүнгээс 1,453.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**График 1.** Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 356.7 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 53.2 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол нийгмийн даатгалын сангийн орлого 120.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 16.8 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 49.5 хувь буюу 2,822.6 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 14.5 хувь буюу 1,207.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төсвийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 35.1 пунктээр их гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,614.7 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

**Хүснэгт 1.** Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөгөөр

	ӨО-ны мөн үе	2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйц.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,540.2	-790.1	1,269.6	-160.7	2,059.7
Засгийн газрын бонд	-72.0	2,316.1	-451.8	-19.5	-2,767.9
Засгийн газрын зээл	1,164.3	653.2	220.9	33.8	-432.4
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	311.7	0.0	0.0	-311.7
Өмч хувьчлал	24.0	4.0	3.2	79.0	-0.8
<b>НИЙТ ДҮН</b>	<b>2,656.5</b>	<b>2,495.0</b>	<b>1,041.8</b>	<b>41.8</b>	<b>-1,453.2</b>

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны эхний 8 сарын байдлаар гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 539.4 тэрбум төгрөг төлсөн бол урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 90.5 тэрбум төгрөг, гадаад бондын үндсэн төлбөрт 3,163.4 тэрбум төгрөг тус тус төлөгдсөн байна. Засгийн газар урт болон богино хугацаат дотоод бонд шинээр гаргаагүй бол 2,802.1 тэрбум төгрөгийн урт хугацаат гадаад бонд шинээр гаргажээ. Харин 475.2 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл, 285.0 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл авсан байна.

**Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 8,522.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 49.5 хувь буюу 2,822.6 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 0.9 хувь буюу 73.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.**

## 2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл улсын төсөв 5.5 хувь буюу 356.7 тэрбум, орон нутгийн төсөв 2.3 хувь буюу 53.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дутуу төвлөрсөн бол нийгмийн даатгалын сангийн төсөв 7.9 хувь буюу 120.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 2.6 хувь буюу 16.8 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 52.2 хувь буюу 2,089.0 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 13.0 хувь буюу 262.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн орлого 26.0 хувь буюу 341.0 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2.3 дахин буюу 372.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


**Хүснэгт 2.** Нэгдсэн төсвийн орлогын 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,484.6	7,360.4	2,334.3	2,281.1	1,532.7	1,653.2	638.1	654.8
ИРЭЭДҮЙН ӨВ САН	726.8	799.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	311.7	471.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,446.1	6,089.4	2,334.3	2,281.1	1,532.7	1,653.2	638.1	654.8
<b>Татварын орлого</b>	<b>5,172.7</b>	<b>5,186.0</b>	<b>991.3</b>	<b>986.9</b>	<b>1,140.6</b>	<b>1,261.0</b>	<b>638.1</b>	<b>654.8</b>
Орлогын албан татвар	1,767.8	1,790.4	667.6	668.7	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	1,140.6	1,261.0	638.1	654.8
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	127.6	113.1	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,770.6	1,788.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	588.1	569.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	10.8	9.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	608.5	608.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	426.9	419.5	196.1	205.1	0.0	0.0	0.0	0.0
<b>Татварын бус орлого</b>	<b>1,273.5</b>	<b>903.3</b>	<b>1,343.0</b>	<b>1,294.2</b>	<b>392.2</b>	<b>392.2</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Нийтлэг татварын бус орлого	810.4	794.2	164.3	141.8	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.8	0.7	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	126.7	71.7	10.7	4.7	392.2	392.2	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	336.4	37.4	1,167.1	1,147.0	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

**График 2.** Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 88.3 хувийг татварын орлого, 11.7 хувийг татварын бус орлого эзэлж байна.




**Татварын орлого 7,526.5 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 2.3 хувь буюу 167.1 тэрбум төгрөгөөр давж биелжээ.**



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 45.9 хувь буюу 2,366.4 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 84.6 хувь буюу 456.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Татварын орлогын 32.7 хувийг орлогын албан татвар, 18.0 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.5 хувийг хөрөнгийн албан татвар, 23.8 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 7.6 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 8.1 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 8.3 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

**График 3.** Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Сангийн яам

**Төлөвлөснөөс давж биелсэн.**

Тайлант хугацаанд **татварын орлого** 2.3 хувь буюу 167.1 тэрбум төгрөгөөр давж биелэхэд орлогын албан татвар 1.0 хувь /23.7 тэрбум төгрөг/, нийгмийн даатгалын орлого 13.2 хувь /158.0 тэрбум төгрөг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 1.0 хувь /17.9 тэрбум төгрөг/, бусад татвар, төлбөр, хураамжийн орлого 0.3 хувь /1.7 тэрбум төгрөг/-иар **төлөвлөснөөс давж биелсэн** нь нөлөөлжээ.

**Төлөвлөснөөс дутуу биелсэн.**

Төлөвлөгөөтэй харьцуулахад хөрөнгийн албан татвар 11.4 хувь /14.5 тэрбум төгрөг/, онцгой албан татвар 3.1 хувь /18.3 тэрбум төгрөг/, тусгай зориулалтын орлого 10.4 хувь /1.1 тэрбум төгрөг/, гадаад үйл ажиллагааны орлого 0.1 хувь /0.4 тэрбум төгрөг/-иар тус тус **төлөвлөснөөс дутуу төвлөрчээ.**


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр татварын орлого 45.9 хувь буюу 2,366.4 тэрбум төгрөгөөр өсөхөд тусгай зориулалтын орлого 0.5 тэрбум (5.0 хувь) төгрөгөөр буурсан ч орлогын албан татвар 1,178.7 тэрбум (92.1 хувь), нийгмийн даатгалын орлого 339.4 тэрбум (33.5 хувь), хөрөнгийн албан татвар 20.1 тэрбум (21.6 хувь), нэмэгдсэн өртгийн албан татвар 430.6 тэрбум (31.7 хувь), онцгой албан татвар 66.1 тэрбум (13.1 хувь), гадаад үйл ажиллагааны орлого 133.6 тэрбум (28.2 хувь), бусад татвар, төлбөр, хураамжийн орлого 198.4 тэрбум (46.6 хувь) төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

“**Татварын бус орлого 995.5 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 456.2 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 93.6 тэрбум төгрөг буюу 8.6 хувиар дутуу биелжээ.**

Төлөвлөгөөтэй харьцуулахад торгуулийн орлого 3.7 тэрбум, газрын тосны орлого 32.3 тэрбум төгрөгөөр давж биелснээс бусад бүх төрлийн татварын бус орлого дутуу төвлөрсөн гүйцэтгэлтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.2 тэрбум, гадаад хандив тусламжийн орлого 54.8 тэрбум, нийтлэг татварын бус орлого 38.6 тэрбум, түүн дотор хувьцааны ногдол ашиг 10.6 тэрбум төгрөг, хүүгийн орлого 6.1 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 29.3 тэрбум, навигацийн орлого 27.0 тэрбум, бусад орлого 1.7 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрчээ.

**График 4.** Татварын бус орлогын бүтэц /Хувиар/



Татварын бус орлогын 94.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 5.9 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийт татварын бус орлогод эзлэх нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 2.3 хувийг хувьцааны ногдол ашиг, 3.7 хувийг хүүгийн орлого, 5.3 хувийг торгуулийн орлого, 20.6 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.3 хувийг түрээсийн орлого, 14.4 хувийг газрын тосны орлого, 5.4 хувийг навигацийн орлого эзэлсэн бол 42.0 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

“**Татварын ерөнхий газар 4.8 хувиар төлөвлөгөөг давуулан биелүүлсэн бол Таалийн ерөнхий газар 3.3 хувиар дутуу биелүүлсэн үзүүлэлттэй байна.**

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн дагуу нийт 18 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 9 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол үлдсэн 9 нь 9.2-54.5 хувиар дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна.

**Хүснэгт 3.** 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны мөн үе	2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Сангийн сайд	4,187,983.0	6,660,517.9	6,937,965.8	277,447.9	104.2
Татварын ерөнхий газар	2,159,318.2	4,001,580.5	4,194,564.3	192,983.9	104.8
Үүнээс: Тогтворжуулалтын санд	20,591.0	311,742.1	471,601.3	159,859.2	151.3
Ирээдүйн өв санд	364,241.5	610,696.1	594,614.3	-16,081.8	97.4
Гаалийн ерөнхий газар	1,869,685.1	2,345,150.5	2,268,630.7	-76,519.8	96.7
Сангийн яам	77,227.4	197,345.2	410,578.6	213,233.3	208.1
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	76,011.2	113,616.9	58,771.7	-54,845.2	51.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,741.0	2,824.8	5,420.4	2,595.6	191.9

<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b>	<b>67.5</b>	<b>66.7</b>	<b>43.0</b>	<b>-23.7</b>	<b>64.5</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	67.5	66.7	43.0	-23.7	64.5
<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>10,563.7</b>	<b>107,212.4</b>	<b>211,164.9</b>	<b>103,952.5</b>	<b>197.0</b>
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	5,107.4	106,486.6	210,466.5	103,979.9	197.6
Үүнээс: Ирээдүйн өв санд	0.0	92,731.1	204,821.2	112,090.1	220.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,456.2	725.8	698.4	-27.4	96.2
<b>Монгол Улсын Шадар сайд</b>	<b>11,806.3</b>	<b>8,639.4</b>	<b>9,345.6</b>	<b>706.2</b>	<b>108.2</b>
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	1,615.3	2,600.0	2,122.9	-477.1	81.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	10,191.0	6,039.4	7,222.7	1,183.3	119.6
<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>	<b>30,554.7</b>	<b>37,509.5</b>	<b>34,065.6</b>	<b>-3,443.9</b>	<b>90.8</b>
Улсын бүртгэлийн ерөнхий газар	8,106.4	11,333.3	10,872.6	-460.7	95.9
Цагдаагийн ерөнхий газар	921.7	3,333.3	856.8	-2,476.6	25.7
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	5,486.8	7,086.5	6,515.1	-571.4	91.9
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	16,039.8	15,756.3	15,821.1	64.7	100.4
<b>Гадаад харилцааны сайд</b>	<b>3,077.4</b>	<b>7,628.5</b>	<b>4,035.1</b>	<b>-3,593.5</b>	<b>52.9</b>
Дипломат төлөөлөгчийн газрууд	2,889.4	6,596.9	4,007.8	-2,589.1	60.8
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	188.0	1,031.6	27.2	-1,004.4	2.6
<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b>	<b>64,778.8</b>	<b>85,032.1</b>	<b>59,811.2</b>	<b>-25,220.9</b>	<b>70.3</b>
Иргэний нисэхийн ерөнхий газар	58,200.0	81,099.7	54,118.2	-26,981.5	66.7
Зам, тээврийн хөгжлийн яам	144.0	142.4	150.0	7.6	105.4
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	6,434.8	3,790.0	5,543.0	1,753.0	146.3
<b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b>	<b>77,170.5</b>	<b>140,295.7</b>	<b>192,253.6</b>	<b>51,957.8</b>	<b>137.0</b>
Ашигт малтмал, газрын тосны газар	75,973.7	139,159.1	191,225.5	52,066.4	137.4
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,196.8	1,136.6	1,028.1	-108.5	90.5
<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>23,222.3</b>	<b>23,169.8</b>	<b>24,344.4</b>	<b>1,174.6</b>	<b>105.1</b>
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	104.8	403.7	0.0	-403.7	-
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	414.2	491.1	642.6	151.5	130.8
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	22,703.3	22,274.9	23,701.7	1,426.8	106.4
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>35,133.2</b>	<b>50,711.8</b>	<b>32,468.2</b>	<b>-18,243.7</b>	<b>64.0</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	35,133.2	50,711.8	32,468.2	-18,243.7	64.0
<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>15,794.7</b>	<b>3,297.4</b>	<b>2,828.1</b>	<b>-469.3</b>	<b>85.8</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	15,794.7	3,297.4	2,828.1	-469.3	85.8
<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b>	<b>563.8</b>	<b>244.4</b>	<b>1,323.0</b>	<b>1,078.6</b>	<b>541.4</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	563.8	244.4	1,323.0	1,078.6	541.4
<b>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>	<b>47.7</b>	<b>6,438.3</b>	<b>3,880.8</b>	<b>-2,557.5</b>	<b>60.3</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	47.7	6,438.3	3,880.8	-2,557.5	60.3
<b>Боловсрол, шинжлэх ухааны сайд</b>	<b>1,152.7</b>	<b>3,283.0</b>	<b>1,492.2</b>	<b>-1,790.8</b>	<b>45.5</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,152.7	3,283.0	1,492.2	-1,790.8	45.5
<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>	<b>973.3</b>	<b>1,485.8</b>	<b>1,165.0</b>	<b>-320.8</b>	<b>78.4</b>
Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	973.3	1,365.8	1,165.0	-200.8	85.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	120.0	0.0	-120.0	-
<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>21,567.6</b>	<b>32,716.6</b>	<b>38,535.6</b>	<b>5,819.0</b>	<b>117.8</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	5,057.7	5,488.7	5,749.0	260.3	104.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	16,509.9	27,227.9	32,786.6	5,558.7	120.4
<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b>	<b>319.2</b>	<b>80.0</b>	<b>295.8</b>	<b>215.8</b>	<b>369.8</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	319.2	80.0	295.8	215.8	369.8
<b>Санхүүгийн зохицуулах хороо</b>	<b>1,402.5</b>	<b>1,139.4</b>	<b>2,375.6</b>	<b>1,236.2</b>	<b>208.5</b>
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,402.5	1,139.4	2,375.6	1,236.2	208.5

**Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,207.9 тэрбум төгрөг буюу 14.5 хувиар өсөж 9,563.8 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.**

### 3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 10,943.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 87.4 хувийг зарлагдаж 1,379.7 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,207.9 тэрбум төгрөг буюу 14.5 хувиар өсөж 9,563.8 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

**Хүснэгт 4.** Нэгдсэн төсвийн зарлагын 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>8,537.8</b>	<b>7,636.9</b>	<b>2,588.3</b>	<b>1,663.9</b>	<b>1,628.0</b>	<b>1,679.2</b>	<b>692.1</b>	<b>740.4</b>
НИЙТ ЗАРЛАГА	8,635.7	7,522.6	2,557.6	1,650.7	1,731.7	1,685.2	828.5	745.8
УРСГАЛ ЗАРДАЛ	7,182.2	6,483.3	2,162.5	1,472.9	1,731.7	1,685.2	828.5	745.8
Бараа, ажил, үйлчилгээний зардал	1,833.1	1,445.3	1,564.1	1,309.0	17.5	15.9	110.6	12.3
Зээлийн үйлчилгээний төлбөр	575.2	486.8	2.2	2.2	0.0	0.0	0.0	0.0
Татаас	550.7	510.3	134.4	101.7	0.0	0.0	41.9	40.9
Урсгал шилжүүлэг	4,223.3	4,040.9	461.8	60.0	1,714.2	1,669.3	676.0	692.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,453.5	1,039.3	395.1	177.9	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-97.9	114.3	30.8	13.1	-103.7	-6.0	-136.4	-5.5
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-2,091.7</b>	<b>-1,547.6</b>	<b>-254.1</b>	<b>617.2</b>	<b>-95.2</b>	<b>-26.0</b>	<b>-54.0</b>	<b>-85.5</b>

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд улсын төсвийн зарлага 900.9 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 924.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс тус тус дутуу зарцуулагдсан бол нийгмийн даатгалын сангийн зарлага 51.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 48.3 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 1,049.5 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 57.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 486.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан бол орон нутгийн төсвийн зарлага 143.2 тэрбум төгрөгөөр буурч зарцуулагдсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 14.5 хувь буюу 1,207.9 тэрбум төгрөгөөр өсөхөд хөрөнгийн зардал 30.7 хувь буюу 538.9 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 24.9 хувь буюу 1,640.3 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 106.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

**Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.3 хувь буюу 6.4 тэрбум төгрөгөөр өссөн бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 15.3 хувь буюу 88.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан**



**Хүснэгт 5.** Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	ӨО-ны мөн үе	2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>8,356.0</b>	<b>10,943.5</b>	<b>9,563.8</b>	<b>87.4</b>	<b>-1,379.7</b>
НИЙТ ЗАРЛАГА	8,346.4	11,250.8	9,447.8	84.0	-1,803.0
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,590.4</b>	<b>9,402.3</b>	<b>8,230.7</b>	<b>87.5</b>	<b>-1,171.6</b>
<b>БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,800.4</b>	<b>3,334.8</b>	<b>2,611.4</b>	<b>78.3</b>	<b>-723.4</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,678.0	1,742.1	1,620.2	93.0	-121.9
Үндсэн цалин	1,183.0	1,187.9	1,141.6	96.1	-46.3
Нэмэгдэл	370.0	428.1	371.1	86.7	-57.0
Унаа, хоолны хөнгөлөлт	38.2	38.5	33.9	88.0	-4.6
Урамшуулал	68.4	67.1	55.2	82.1	-12.0
Гэрээт ажлын хөлс	18.4	20.5	18.5	90.2	-2.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>-</b>	<b>0.0</b>
Тэтгэврийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэмжийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
ҮОМШӨ-ний даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Ажилгүйдлийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Эрүүл мэндийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>156.2</b>	<b>184.4</b>	<b>151.4</b>	<b>82.1</b>	<b>-33.0</b>
Гэрэл, цахилгаан	31.7	37.2	27.8	74.7	-9.4
Түлш, халаалт	95.4	109.7	96.1	87.6	-13.7
Цэвэр, бохир ус	12.4	15.8	9.1	57.9	-6.6
Байрны түрээс	16.6	21.7	18.4	84.9	-3.3
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>98.8</b>	<b>118.9</b>	<b>95.2</b>	<b>80.0</b>	<b>-23.7</b>
Бичиг хэрэг	8.1	7.8	6.1	78.8	-1.7
Тээвэр, шатахуун	36.9	44.2	35.4	80.1	-8.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8.3	9.8	7.3	74.7	-2.5
Ном, хэвлэл	3.0	5.2	0.9	18.2	-4.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33.7	43.5	38.8	89.3	-4.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	9.0	8.4	6.6	77.9	-1.9
<b>Нормативт зардал</b>	<b>213.1</b>	<b>180.8</b>	<b>109.5</b>	<b>0.0</b>	<b>-71.3</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90.1	92.4	58.8	63.6	-33.6
Хоол, хүнс	92.9	53.8	28.8	53.5	-25.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	30.0	34.6	22.0	63.4	-12.7
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>45.5</b>	<b>75.0</b>	<b>37.1</b>	<b>49.4</b>	<b>-37.9</b>
Багаж, техник, хэрэгсэл	22.8	27.8	13.1	47.0	-14.8
Тавилга	1.2	3.4	1.4	39.6	-2.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1.6	4.6	1.4	31.8	-3.1
Урсгал засвар	19.9	39.2	21.2	54.1	-18.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8.7</b>	<b>19.7</b>	<b>7.6</b>	<b>38.4</b>	<b>-12.2</b>
Гадаад албан томилолт	2.6	6.7	2.4	36.1	-4.3
Дотоод албан томилолт	4.7	9.1	3.4	37.1	-5.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	1.4	3.9	1.8	45.5	-2.1
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>379.1</b>	<b>547.4</b>	<b>357.5</b>	<b>65.3</b>	<b>-189.9</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	353.0	499.9	333.7	66.8	-166.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1.6	2.2	1.2	54.3	-1.0

Даатгалын үйлчилгээ	7.4	14.2	10.7	75.5	-3.5
Тээврийн хэрэгслийн татвар	0.8	0.9	0.3	39.5	-0.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.1	0.2	0.1	45.2	-0.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7.8	17.4	6.6	38.0	-10.8
Газрын төлбөр	0.6	1.6	0.7	41.2	-0.9
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1.0	3.4	1.2	35.6	-2.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6.6	7.7	3.1	39.7	-4.6
<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>221.1</b>	<b>466.5</b>	<b>233.0</b>	<b>49.9</b>	<b>-233.5</b>
Бараа, үйлчилгээний бусад зардал	202.8	439.0	218.0	49.7	-221.0
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	18.3	27.5	15.0	54.5	-12.5
<b>ХҮҮ</b>	<b>482.6</b>	<b>577.4</b>	<b>489.0</b>	<b>84.7</b>	<b>-88.4</b>
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	431.3	481.8	423.2	87.8	-58.6
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	51.3	95.5	65.7	68.8	-29.8
<b>ТАТААС</b>	<b>247.7</b>	<b>334.8</b>	<b>260.7</b>	<b>77.8</b>	<b>-74.2</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	67.9	59.9	36.5	60.9	-23.4
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	179.8	275.0	224.2	81.5	-50.8
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,059.7</b>	<b>5,155.3</b>	<b>4,869.7</b>	<b>94.5</b>	<b>-285.6</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	111.8	671.4	563.6	83.9	-107.8
Засгийн газрын дотоод шилжүүлэг	109.1	666.2	560.7	84.2	-105.6
Засгийн газрын гадаад шилжүүлэг	2.7	5.2	3.0	57.1	-2.2
Бусад урсгал шилжүүлэг	2,947.9	4,483.8	4,306.0	96.0	-177.8
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,604.9	1,713.6	1,668.8	97.4	-44.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	962.1	1,359.9	1,319.1	97.0	-40.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3.0	49.6	36.8	74.2	-12.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	275.7	221.1	192.9	87.2	-28.2
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67.2	77.0	56.1	72.9	-20.9
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26.2	38.1	25.9	68.0	-12.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8.8	1,024.4	1,006.3	98.2	-18.1
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,756.1</b>	<b>1,848.6</b>	<b>1,217.2</b>	<b>65.8</b>	<b>-631.4</b>
Барилга байгууламж	1,100.1	1,020.7	736.5	72.2	-284.1
Их засвар	64.1	72.9	40.2	55.2	-32.7
Тоног төхөөрөмж	235.9	225.6	117.5	52.1	-108.1
Бусад хөрөнгө	342.0	515.3	316.9	61.5	-198.3
Стратегийн нөөц хөрөнгө	14.0	14.1	6.0	42.6	-8.1
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>9.5</b>	<b>-307.3</b>	<b>116.0</b>	<b>-37.7</b>	<b>423.3</b>
Эргэж төлөгдөх зээл	-53.2	-450.6	21.3	-4.7	471.9
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	62.7	143.4	94.7	66.1	-48.7

Эх сурвалж: Сангийн яам




**Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 86.1 хувьд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 7.2 пунктээр нэмэгдсэн байна.**



Нэгдсэн төсвийн нийт зарлагын 8,230.7 тэрбум төгрөг буюу 86.1 хувь нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 59.2 хувийг урсгал шилжүүлэг, 31.7 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 5.9 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.2 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,640.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 189.0 тэрбум төгрөгөөр буурсан ч зээлийн үйлчилгээний төлбөр 6.4 тэрбум, татаас 13.0 тэрбум, урсгал шилжүүлэг 1,809.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

**График 5.** Урсгал зардлын бүтэц /Хувиар/



**Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар 32 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн нийт зарлагын төсөв 900.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 89.4 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.**



Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 38.0 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 19.7 хувийг Сангийн сайдын багц, 12.8 хувийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц, 7.6 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 5.1 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, үлдэх 16.7 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын төсвийн зардал эзэлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч	2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	7,454.9	4,896.2	2,558.7	65.7
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	37,618.5	33,777.5	3,841.0	89.8
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	113,059.9	89,130.6	23,929.3	78.8
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	46,471.9	28,055.5	18,416.4	60.4
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	70,403.6	53,961.7	16,441.9	76.6
САНГИЙН САЙД	1,883,432.9	1,505,721.6	377,711.3	79.9
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	186,462.6	167,836.3	18,626.3	90.0
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	646,822.7	583,040.1	63,782.6	90.1
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1,678.7	1,376.2	302.5	82.0
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	3,012.9	2,332.5	680.4	77.4
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	42,104.4	36,330.6	5,773.9	86.3
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	39,852.8	30,458.9	9,393.9	76.4
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	3,785.9	3,416.0	370.0	90.2
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	15,980.0	12,913.6	3,066.4	80.8
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	6,361.9	6,101.3	260.6	95.9
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	4,164.7	2,517.5	1,647.1	60.4
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	1,959.9	937.9	1,022.0	47.9
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА	5,261.3	5,194.6	66.7	98.7
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	356,168.1	285,250.6	70,917.5	80.1
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	27,631.8	23,533.3	4,098.5	85.2
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	926.4	761.8	164.6	82.2
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	22,516.2	15,617.9	6,898.4	69.4
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	106,150.8	71,386.8	34,764.0	67.3
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	437,165.3	391,293.7	45,871.6	89.5
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	59,679.5	58,628.1	1,051.5	98.2
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	1,042,658.8	978,371.8	64,286.9	93.8
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	108,026.6	105,768.1	2,258.5	97.9
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	20,371.6	18,720.8	1,650.8	91.9
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	157,670.4	147,111.5	10,558.9	93.3
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	35,105.2	27,261.8	7,843.4	77.7
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	2,987,489.6	2,903,251.5	84,238.0	97.2
СОЁЛЫН САЙД	60,346.8	41,988.7	18,358.0	69.6
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>8,537,796.4</b>	<b>7,636,944.7</b>	<b>900,851.8</b>	<b>89.4</b>

Эх сурвалж: Сангийн яам

**2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 378.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 372.8 тэрбум төгрөгийг зарцуулж Улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүн 98.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.**

#### 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2021 онд нийт 1,418.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 378.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 372.8 тэрбум төгрөгийг зарцуулж 98.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

**Хүснэгт 7.** Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Сая төгрөгөөр

Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	2021 оны төсөв	2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
			Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
I	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	1,066.6	0.0	0.0	0.0	0.0
II	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	3,570.3	0.0	0.0	0.0	0.0
III	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	32,830.4	7,267.9	7,267.9	0.0	100.0
IV	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	22,015.1	13,873.0	13,873.0	0.0	100.0
V	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	30,963.1	7,504.2	7,504.2	0.0	100.0
VI	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	18,045.0	6,058.0	6,058.0	0.0	100.0
VII	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	6,150.0	2,968.2	2,968.2	0.0	100.0
VIII	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	4,349.4	3,753.9	3,753.8	0.0	100.0
IX	САНГИЙН САЙД	88,186.3	15,335.6	15,335.6	0.0	100.0
X	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	29,157.0	21,165.3	21,165.3	0.0	100.0
XI	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	24,635.9	4,345.5	4,345.5	0.0	100.0
XII	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	193,290.3	46,643.2	46,641.7	1.5	100.0
XIII	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	361,831.5	104,261.7	104,212.5	49.2	100.0
XIV	СОЁЛЫН САЙД	92,839.1	25,032.7	19,789.7	5,243.1	79.1
XV	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	233,601.3	80,324.9	80,324.8	0.1	100.0
XVI	УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	1,727.1	971.1	971.1	0.0	100.0
XVII	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	21,122.4	2,203.5	2,203.5	0.0	100.0
XVIII	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	38,052.8	9,322.2	9,322.1	0.0	100.0
XIX	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	188,034.7	18,975.9	18,975.9	0.0	100.0
XX	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	1,150.0	1,002.5	1,002.5	0.0	100.0
XXI	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	4,000.0	2,145.0	2,145.0	0.0	100.0
XXII	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	20,312.9	4,748.8	4,748.8	0.0	100.0
XXIII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,497.3	186.7	186.7	0.0	100.0
XXIV	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	492.5	0.0	0.0	0.0	-
	<b>НИЙТ</b>	<b>1,418,921.0</b>	<b>378,090.0</b>	<b>372,796.0</b>	<b>5,294.0</b>	<b>98.6</b>

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд “Барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэх 266.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг санхүүжүүлэхээр төсөвлөснөөс эхний 8 сарын байдлаар 205.6 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тусгаж, 189.9 тэрбум төгрөг буюу 92.4 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

**Хүснэгт 8.** Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Сая төгрөгөөр


ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл				
	Төсөв	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	266,268.7	205,573.9	189,853.3	15,720.6	92.4
Төрийн худалдан авах ажиллагааны газар	266,268.7	205,573.9	189,853.3	15,720.6	92.4
Концессын төслийн эргэн төлөлт	266,268.7	205,573.9	189,853.3	15,720.6	92.4
I.Барилга байгууламж	266,268.7	205,573.9	189,853.3	15,720.6	92.4
<b>Шилжих</b>	<b>134,879.1</b>	<b>134,879.1</b>	<b>129,853.3</b>	<b>5,025.8</b>	<b>96.3</b>
“Чойр” дэд станцын өргөтгөл, шинэчлэлт	14,100.3	14,100.3	14,100.3	0.0	100.0
Төрөх эмнэлгийн барилгын дуусгал, дэд бүтэц, 300 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	30,778.8	30,778.8	30,753.0	25.8	99.9
Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл	45,000.0	45,000.0	40,000.0	5,000.0	88.9
Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл	45,000.0	45,000.0	45,000.0	0.0	100.0
<b>Шинэ</b>	<b>131,389.6</b>	<b>70,694.8</b>	<b>60,000.0</b>	<b>10,694.8</b>	<b>84.9</b>
Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл/Баянхонгор/	131,389.6	70,694.8	60,000.0	10,694.8	84.9

Эх сурвалж: Сангийн яам



## 5. Нийгмийн даатгалын сан

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/




### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН



-Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үеэс)

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 1,679.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 57.7 тэрбум төгрөг буюу 3.6 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 91.4 тэрбум, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 11.6 тэрбум, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 78.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 59.3 тэрбум төгрөгөөр буурчээ.


**График 6.** Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/



## 6. Эрүүл мэндийн даатгалын сан

“ Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 2.6 хувиар давж биелжээ. ”


**График 7.** Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Эрүүл мэндийн даатгалын санд 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 654.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 2.6 хувь буюу 16.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

“ Эрүүл мэндийн даатгалын сангаас 740.4 тэрбум төгрөгийн зарлага хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 486.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. ”

**График 8.** Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 692.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 740.4 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн гүйцэтгэл 107.0 хувьтай гарчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 486.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.



## 7. Орон нутгийн төсөв

2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 924.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

**2021** оны эхний 8 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 2,281.1 тэрбум төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 2.3 хувь буюу 53.2 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 1,663.9 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 35.7 хувь буюу 924.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, орон нутгийн төсвийн тэнцэл 617.2 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 13.0 хувиар буюу 262.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 7.9 хувь буюу 143.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 49.7 хувийг орон нутгийн орлого, 39.5 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 5.2 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 5.5 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 119.3 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 901.2 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг олгохоор төлөвлөсөн нь тус бүр 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэгт 146.6 тэрбум төгрөг шилжүүлэхээр төлөвлөснөөс 126.5 тэрбум төгрөг шилжүүлсэн нь 86.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

**График 9.** Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



**Хүснэгт 9.** Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Сая төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	8,040.3	8,040.3	100.0	30,470.0	30,470.0	100.0	3,810.3	3,513.6	92.2
Баян-Өлгий	4,243.9	4,243.9	100.0	41,745.3	41,745.3	100.0	5,183.2	4,698.1	90.6
Баянхонгор	11,756.8	11,756.8	100.0	31,657.1	31,657.1	100.0	4,512.1	4,117.7	91.3
Булган	2,360.0	2,360.0	100.0	22,782.7	22,782.7	100.0	2,507.3	2,199.7	87.7
Говь-Алтай	9,373.6	9,373.6	100.0	27,435.1	27,435.1	100.0	6,481.9	5,569.7	85.9
Дорноговь	0.0	0.0	0.0	23,665.9	23,665.9	100.0	13,472.9	10,177.4	75.5

Дорнод	0.0	0.0	0.0	27,927.9	27,927.9	100.0	5,511.9	5,170.3	93.8
Дундговь	7,444.5	7,444.5	100.0	17,854.2	17,854.2	100.0	4,026.3	3,479.4	86.4
Завхан	11,872.8	11,872.8	100.0	29,141.3	29,141.3	100.0	3,482.1	3,307.8	95.0
Өвөрхангай	11,231.3	11,231.3	100.0	37,389.9	37,389.9	100.0	4,344.8	4,344.8	100.0
Өмнөговь	0.0	0.0	0.0	24,953.7	24,953.7	100.0	11,589.3	8,797.1	75.9
Сүхбаатар	5,947.5	5,947.5	100.0	20,612.5	20,612.5	100.0	12,221.0	9,560.3	78.2
Сэлэнгэ	3,214.8	3,214.8	100.0	36,628.8	36,628.8	100.0	6,857.5	5,873.4	85.6
Төв	6,029.6	6,029.6	100.0	31,357.0	31,357.0	100.0	5,881.1	5,122.3	87.1
Увс	9,526.6	9,526.6	100.0	32,168.7	32,168.7	100.0	4,433.7	4,019.0	90.6
Ховд	6,155.2	6,155.2	100.0	30,670.2	30,670.2	100.0	9,008.7	7,599.2	84.4
Хөвсгөл	12,621.8	12,621.8	100.0	46,175.2	46,175.2	100.0	5,631.7	5,631.7	100.0
Хэнтий	8,575.7	8,575.7	100.0	29,411.1	29,411.1	100.0	6,386.7	5,677.0	88.9
Дархан-Уул	0.0	0.0	0.0	25,810.2	25,810.2	100.0	5,896.2	5,190.8	88.0
Улаанбаатар	0.0	0.0	0.0	300,375.9	300,375.9	100.0	21,140.6	18,425.3	87.2
Орхон	0.0	0.0	0.0	27,441.2	27,441.2	100.0	3,235.1	3,098.3	95.8
Говьсүмбэр	925.3	925.3	100.0	5,558.5	5,558.5	100.0	977.1	909.9	93.1
<b>ДҮН</b>	<b>119,319.7</b>	<b>119,319.7</b>	<b>100.0</b>	<b>901,232.5</b>	<b>901,232.5</b>	<b>100.0</b>	<b>146,591.5</b>	<b>126,482.7</b>	<b>86.3</b>

Эх сурвалж: Сангийн яам

Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 53.2 тэрбум төгрөг буюу 2.3 хувиар дутуу төвлөрсөн нь орон нутгийн орлого 2.8 хувь буюу 33.0 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг 13.7 хувь буюу 20.1 тэрбум төгрөгөөр дутуу шилжсэнтэй холбоотой байна.

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 901.2 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгожээ. Харин орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилахаар 146.6 тэрбум төгрөг төсөвлөсний 86.3 хувь буюу 126.5 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал; Дорноговь аймаг 10,314.3 сая, Дорнод аймаг 945.0 сая, Дундговь аймаг 521.0 сая, Өмнөговь аймаг 20,631.3 сая, Сүхбаатар аймаг 3,612.6 сая, Улаанбаатар хот 51,832.4 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлсэн бол Архангай аймаг 1,194.1 сая, Баянхонгор аймаг 1,839.8 сая, Баян-Өлгий аймаг 715.7 сая, Булган аймаг 3,415.2 сая, Говь-Алтай аймаг 406.7 сая, Завхан аймаг 1,785.3 сая, Өвөрхангай аймаг 131.7 сая, Сэлэнгэ аймаг 3,781.6 сая, Төв аймаг 2,573.1 сая, Увс аймаг 1,934.8 сая, Ховд аймаг 335.2 сая, Хөвсгөл аймаг 4,343.8 сая, Хэнтий аймаг 316.8 сая, Дархан-Уул аймаг 1,650.6 сая, Говьсүмбэр аймаг 2,435.7 сая, Орхон аймаг 7,839.6 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**